

**ГАРЧИГ**

<b>НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....</b>	<b>2</b>
<b>ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ.</b>	<b>6</b>
<b>ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЭЛЭЛТ .....</b>	<b>6</b>
<b>ДӨРӨВ. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ....</b>	<b>16</b>
<b>ДОЛОО. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....</b>	<b>21</b>
<b>НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....</b>	<b>24</b>
<b>ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....</b>	<b>24</b>
<b>АРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ</b>	
<b>ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ..</b>	<b>27</b>
<b>ДҮГНЭЛТ.....</b>	<b>35</b>

## НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Төслийн ерөнхий мэдээлэл


Хүснэгт 1. Төслийн товч тодорхойлолт, үндсэн үзүүлэлтүүд

№	ҮЗҮҮЛЭЛТ	УТГА
1	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	“КҮНЛҮН” ХХК
2	Төсөл хэрэгжүүлэгчийн улсын бүртгэлийн мэдээлэл	Улсын бүртгэлийн дугаар: 9019006127 Бүртгэсэн огноо: 2005.12.19 Регистрийн дугаар: 2745534
3	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 3-р хороо, Налайх гол-1
4	Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын удирдлагын мэдээлэл	Захирал: Liu Yang Утас: 9925-4796
5	Төслийн нэр	Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Налайх гол-1” нэртэй тоосгоны шаврын ордыг ил уурхайн аргаар ашиглах, тоосго үйлдвэрлэх төсөл
6	Төслийн байршил	Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 3-р хороо
7	Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар	MV-009192
8	Тусгай зөвшөөрлийн хугацаа	Олгосон огноо : 2005.01.24 Дуусах огноо: 2035.01.24
9	Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ	4.04 га
10	Ордын батлагдсан геологийн нөөц	183.23 мян.м3 (2017 оны ТЭЗҮ)
11	Ордын үйлдвэрлэлийн нөөц	132.05 мян.м3 (2017 оны ТЭЗҮ)
12	Шавар олборлолтын жилийн хүчин чадал	13.49 мян.м3
13	Тоосго үйлдвэрлэлийн жилийн хүчин чадал	4.0 сая ширхэг

**Төслийн байршил:** “Налайх гол-1” тоосгоны шаврын уурхай нь засаг захиргааны нэгжийн хувьд Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт хамаарах бөгөөд Улаанбаатар хотын төвөөс 36 км зайд байр зүйн зургийн L-48-11 тоот хавтгайд оршино. Уг орд байрлаж буй нийт 4.04 га талбай бүхий MV-009192 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбилцолыг дараах хүснэгтэд харуулав

Хүснэгт 1. Талбайн солбицлын цэгүүд

Цэгийн дугаар	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	107	18	1.36	47	44	45.78
2	107	18	1.36	47	44	54.78
3	107	17	54.37	47	44	54.78
4	107	17	54.37	47	44	54.37



Зураг 1. Төслийн байршлын зураг

Зураг 2. Бутлан ангилах хэсгийн дамжлагын схем зураг

### Ордын геологийн нөөц

Ордын нөөцийн АМГ-ын даргын 2010 оны 04 сарын 06-ний өдрийн 138 тоот тушаалаар батлагдсан, ЭБМЗ-ийн 2010 оны 02 сарын 27-ний өдрийн №: ХХ-03-07 тоот дүгнэлт мөн АМГ-ын 2016 оны 08 сарын 01-ний өдрийн Н/91 тоот тушаал, ЭБМЗ-ийн 2016 оны 07 сарын 05-ний өдрийн №: ХХ-07-02 тоот дүгнэлт тус тус гарсан. “Күнлүн” ХХК-нь 2016 онд АМГ-ын УУХ-т 2015 оны үйл ажиллагааны тайланг хүргүүлэн нөөцийн хасалт хийгдсэн. Мөн 2016 онд нэмэлт хайгуулын ажил хийж доод давхаргын 4 блокгийн нөөцийг нөөцийн ЭБМЗ-ийг хурлаар батлуулсан байдаг. 2017 онд ТЭЗҮ-ийг боловсруулахдаа дээд давхаргын нөөцийн үлдэгдэл болон шинээр ЭБМЗ-өөр орсон доод давхаргын нөөцөд тулгуурласан байна. “Налайх гол-1” тоосгоны шаврын ордын геологийн нөөц нь 2017 оны 4-р сарын 21-ний байдлаар 183.24 мян.м<sup>3</sup> байна.

Хүснэгт 3 “Налайх гол-1” тоосгоны шаврын ордын батлагдсан геологийн нөөц

№	Нөөцийн блокийн дугаар ба нөөцийн зэрэг	Блокийн талбай, м <sup>2</sup>	Хуулах хөрсний дундаж зузаан, м	Ашигт малтмалын дундаж зузаан, м	Хуулах хөрсний эзэлхүүн, м <sup>3</sup>	Ашигт малтмалын нөөц, м <sup>3</sup>
<b>Дээд давхарга</b>						
1	В-I	1253.00	0.65	2.86	815.00	3584.00
2	В-II	3955.00	0.62	2.70	2452.00	10679.00
3	В-III	13090.00	0.57	2.70	7461.00	34689.00
-	<b>Нийт</b>	<b>18298.00</b>	<b>0.59</b>	<b>2.68</b>	<b>10728.00</b>	<b>48951.60</b>
<b>Доод давхарга</b>						
4	В-1	11568.38	-	7.24	-	83755.07
5	С-1	2893.27	-	7.80	-	22567.51
6	С-2	2669.81	-	6.90	-	18421.69
7	С-3	1316.32	-	7.25	-	9543.32
-	<b>Нийт</b>	<b>18448.00</b>	<b>-</b>	<b>7.28</b>	<b>-</b>	<b>134287.59</b>
<b>Ордын нийт нөөц</b>						
8	В нөөц	29866.70	0.36	4.44	10728.00	132707.00
9	С нөөц	6879.40	-	7.35	-	50533.00
	<b>Нийт</b>	<b>36746.00</b>	<b>0.29</b>	<b>4.99</b>	<b>12777.78</b>	<b>183239.19</b>

**Ордын үйлдвэрлэлийн нөөц**

“Налайх гол-1” тоосгоны шаврын ордыг ил уурхайн аргаар ашиглах үеийн үйлдвэрлэлийн нөөц нь 132.05 мян.м3 байхаар ТЭЗҮ-д тооцож тусгасан байна.

**Уурхайн хүчин чадал, ажиллах горим**

**Уурхайн хүчин чадал:** Уурхайн хүчин чадлыг техник-эдийн засгийн үндэслэлд жилд 13.49 мян.м3 тоосгоны шавар олборлон боловсруулахаар тооцож тусгасан байна.

**Уурхайн ажиллах горим:** “Налайх гол-1” тоосгоны шаврын уурхай нь улирлын чанартай ажиллах бөгөөд 156 хоног ажиллана.

*Хүснэгт 4. Уурхайн ажиллах горим, хүчин чадал*

№	Горимын үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Утга
1	Жилийн хуанлийн хоног	хоног	365
2	Өвлийн улирлын сул зогсолт	хоног	209
3	Жилийн ажиллах хуанлийн хоног	хоног	156
4	Баяр ёслолын амралт	хоног	7
5	Цаг агаарын саатал	хоног	5
6	Засвар үйлчилгээ	хоног	7
7	Олборлолтын ажлын хоног	хоног	153
8	Хоногт ажиллах ээлжийн тоо	ээлж	1
9	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	8
10	Цаг ашиглалтын итгэлцүүр	-	0.8
11	Хоногт ажиллах бодит цаг	цаг	6.4
12	Жилд ажиллах бодит цаг	цаг	1224
13	Уурхайн цагийн хүчин чадал	м <sup>3</sup> /цаг	13.77
14	Уурхайн хоногийн хүчин чадал	м <sup>3</sup> /хоног	88.13
15	Уурхайн жилийн хүчин чадал	м <sup>3</sup> /жил	13485.0

***Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө***

2024 онд уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу 62.67 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 200.0 мян.м<sup>3</sup> барилгын чулуу олборлон 0-5 мм, 5-10 мм, 10-20 мм фракцын бүтээгдэхүүн гаргахаар төлөвлөсөн.

## ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- ✓ ОХШХ-ийн хүрээнд агаар, ус хөрс, шинжилгээ хийлгэсэн.
- ✓ Замын тоосжилтыг дарах зорилгоор тогтмол зам усалгаа хийгддэг.
- ✓ Ус ашиглах гэрээ, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл, бохир соруулах үйлчилгээний гэрээг байгуулж тайланд хавсаргав.
- ✓ Ус ашиглах дүгнэлтийг Туул голын сав газрын захиргаанаас авсанг доор үзүүлэв.
- ✓ Овоолго болон бусад байгууламжуудыг байгуулхын өмнө өнгөн хөрсийг хуулж, өнгөн хөрсний овоолго байгуулж хадгалав.
- ✓ Хүнд машин механизмын явах замыг тогтмол цэвэрлэж, засаж тэмдэгжүүлэв.



БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ  
**ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН  
ЗАХИРГАА**

16050 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2 дугаар хороо,  
Чингунжавын гудамж, Туул голын сав газрын захиргааны байр,  
Утас: 7000-3714, Факс: (976) 7000-3714  
E-mail: TuulRBA@gmail.com

2024.05.02 № АА/313  
танай 2024.04.19 -ны № 24/20 -т

**"КҮН ЛҮН" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ ЛИУ ЖИН ШАН ТАНАА**

Монгол Улсын Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх заалт, танай компанийн 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 24/20 дугаар хүсэлтийг үндэслэн "Тоосгоны шаврын ордыг ил уурхайн аргаар ашиглан, тоосго үйлдвэрлэх үйлдвэр"-ийн 2024 оны ус ашиглуулах дүгнэлтийг гарган хүргүүлж байна.

Ус ашиглуулах дүгнэлтээр тавигдсан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

Хувийг, Нийслэлийн Байгаль орчны газар, Налайх дүүргийн Татварын хэлтэст.

Хавсралт 4 хуудастай, 2 хувь.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Д.НЯМДОРЖ



ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА  
“КҮН ЛҮН” ХХК-ИЙН  
УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2024 оны 05 дугаар сарын 09-ын/ний өдөр

Дугаар УАД 24/...49

Улаанбаатар хот  
Утас: 7000-3716, 7000-3714

**1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр хаяг, утас факс, улсын бүртгэлийн дугаар болон регистрийн дугаар :**

- “Күн лүн” ХХК, Гүйцэтгэх Захирал Лиу Жин Шан, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, 140 мянгат, 7-20 тоот, 9567-9999, 8822-6064, УБД-9019006127, РД-2745534.

**2. Төслийн байршил, харьяалагдах сав газар:**

- “Күн лүн” ХХК-ийн тоосгоны үйлдвэр нь Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрладаг, Туул голын сав газарт хамрагдана.

**3. Төсөл хэрэгжүүлэгч:**

- “Күн лүн” ХХК.

**4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн хэмжээ, координат /X;Y/:**

- Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газраас 2007 онд олгосон MV-0009192A, Барилга хот байгуулалтын яамнаас 2016 онд олгосон БМУ 013/16, 4.04 га талбай, Солбицол: 47°44'45.78", 107°18'1.36", 47°44'45.78", 107°17'54.37"  
47°44'45.77", 107°17'54.37", 47°44'54.77", 107°18'1.36".

**5. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл, зориулалт:**

- “Налайх гол-1” тоосгоны шаврын орддыг ил уурхайн аргаар олборлож, тээвэрлэх, M100-M150 маркийн барилгын ханын улаан тоосго үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулдаг.

**6. Үйлдвэрийн техник, технологи ажиллах горим, хүчин чадал:**

- Ил уурхайд хөрс болон шаврыг ухах ачих болон тээвэрлэх, овоолох гэсэн үндсэн процессуудад XCMG-CLG922 маркийн экскаватор 1 ширхэг, FAW маркийн автосамосвал 2 ширхэг, Luigong ZL-50 маркийн утгуурт ачигч 1 ширхэг, Shantui SD16 маркийн бульдозер 1 ширхэг, 26 амтай шатаах зуух ашигладаг. Үйлдвэр нь түүхий эд бэлтгэх, хагас боловсруулсан тоосго бэлтгэх, шатаах, борлуулах гэсэн үндсэн 4 хэсгээс бүрдэнэ. Жилд дунджаар 10'000.0 м<sup>3</sup> шавар олборлон 5'000'000.0 ширхэг тоосго үйлдвэрлэж, 130-250 хоног 1 ээлжээр нийт 66 хүн ажиллана. /2021 оны Усны газрын боломжит нөөцийн дүгнэлт, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг үндэслэв/.

**7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ:**

- 2024 онд үйлдвэр нь 13'400.0 м<sup>3</sup> шавар олборлон, 3'974'787.0 ширхэг тоосго үйлдвэрлэхээр төлөвлөсөн /2024 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөний 17-р хуудас/.

**8. Усны эх үүсвэр, нөөц, хоногт ашиглах хэмжээ:**

Худгийн дугаар	Солбицол	Гүн, метр	Ундарга, л/сек	Гаргасан он
12750-02731	47°43'59.60" 107°17'35.25"	50.0	0.8	2005

- Үйлдвэрлэх бүтээгдэхүүний хэмжээгээр тооцоход хоногт дунджаар 50.36 м<sup>3</sup> газрын доорх ус ашиглана.

**9. Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, хэмжээ, хийц, дамжуулах шугам сүлжээний урт, диаметр/:**

- Үйлдвэрийн ус хангамжийн зориулалтаар гаргасан 1 гүний худгаас өөр усны барилга байгууламж ашигладаггүй. Зуурагч төхөөрөмжийн дэргэд 10 м<sup>3</sup> эзлэхүүнтэй нөөцийн сантай ба 25 мм диаметртэй ган хоолойгоор зуурах төхөөрөмжтэй холбогддог.

**10. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур /Насосын хүчин чадал, марк/:**

- Худгаас гарч буй технологийн шугам дээр Стандарт, хэмжил зүйн газраас баталгаажуулсан LXSG загварын, 40 мм-ийн голчтой, 2101000201 дугаартай усны тоолуурыг 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр дахин баталгаажуулан суурилуулсан. 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн тоолуурын заалт: 009466 м<sup>3</sup>.

- Тоолуурын хэвийн ажиллагааг хангаж, тоолуурын заалтын тэмдэглэгээг тогтмол хийж,



бичилтийг сар бүр баталгаажуулах шаардлагатай.

**11. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөхцөл:**

- Үйлдвэрийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг 2021 онд “Эхопланет” ХХК гүйцэтгэж, Байгаль орчин, аялал жуулчлалын ямаар батлуулсан байна. Цаашид байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланд тусгагдсан усны нөөц, ус ашиглалтын хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай.

**12. Онцгой нөхцөл:**

- “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6561:2015” стандартаас давсан бохирдолтой хаягдал усыг төвлөрсөн сүлжээнд нийлүүлсэн тохиолдолд Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь заалтын дагуу ус ашиглах эрх цуцлагдах нөхцөл үүсэхийг анхаарах;

**13. Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалтыг тооцох:**

- 2024 онд үйлдвэр нь 3'974'787.0 ширхэг тоосго үйлдвэрлэхээр төлөвлөсөн, Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-оор тооцоов.

1000 ш ердийн тоосго үйлдвэрлэхэд зарцуулах усны хэмжээ:  $0.8 \text{ м}^3$  /Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалын 6 дугаар хавсралт/.

**2024 онд ашиглах үйлдвэрийн усны хэрэглээг урьдчилан тооцоход:**

- Үйлдвэрийн ажилчдын унд ахуйн усны хэрэглээ:  
 $66 \text{ хүн} \times 150 \text{ л/хүн} \times 250 \text{ хон} = 2'475.0 \text{ м}^3/\text{жил}$  (9.9  $\text{м}^3$ /хоног)
- Технологийн усны хэрэглээнд:  
 $3'974'787.0 \text{ ш тоосго} \times 0.8 \text{ м}^3/1000\text{ш} = 3'179.8 \text{ м}^3/\text{жил}$  (24.46  $\text{м}^3$ /хоног)
- Зам талбайн тоосжилт дарахад ашиглах ус:  
 $4000 \text{ м}^2 \times 2 \text{ л} \times 60 \text{ хоног} = 480 \text{ м}^3/\text{жил}$  (8  $\text{м}^3$ /хоног)
- Мод усалгаанд ашиглах ус:  
 $200 \text{ ш} \times 40 \text{ л} \times 9 \text{ хоног} = 72 \text{ м}^3/\text{жил}$  (8  $\text{м}^3$ /хоног)  
 $9.9 \text{ м}^3 + 24.46 \text{ м}^3 + 8 \text{ м}^3 + 8 \text{ м}^3 = 50.36 \text{ м}^3/\text{хоног}$   
**Нийт:**  $2'475.0 \text{ м}^3/\text{жил} + 3'179.8 \text{ м}^3/\text{жил} + 480 \text{ м}^3/\text{жил} + 72 \text{ м}^3/\text{жил} = 6'206.8 \text{ м}^3/\text{жил}$ .

**Төлбөр ногдох ус:**  $6'206.8 \text{ м}^3/\text{жил} - 2'475.0 \text{ м}^3/\text{жил} = 3'731.8 \text{ м}^3/\text{жил}$ .

**14. Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийг урьдчилан байдлаар тооцоход:**

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1-т заасны дагуу унд, ахуйд ашиглах  $2'475.0 \text{ м}^3/\text{жил}$  усыг төлбөрөөс чөлөөлнө.

- Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор батлагдсан “Усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ”, Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолоор батлагдсан “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ”, Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолоор батлагдсан “Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр”-ийг тус тус үндэслэн урьдчилсан байдлаар тооцоход:

**2024 онд ашиглах усны нөөцийн төлбөрт:**

Тоосго үйлдвэрлэхэд ашиглах газрын доорх ус ашигласны төлбөрт:

$$9'440 \text{ төг}/\text{м}^3 \times 20\% \times 0.1 = 188.8 \text{ төгрөг}$$

$9'440 \text{ төг}/\text{м}^3$ -Туул голын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;


20% - Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн зориулалтаар усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ;

0.1- Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны шоо метр тутамд ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр.

$$3'179.8.0 \text{ м}^3 \times 188.8 \text{ төг} = 600'346.0 \text{ /Зургаан зуун мянга гурван зуун дөчин зургаан/ төгрөг.}$$


Зам талбайн тоосжилт дарахад ашиглах газрын доорх ус ашигласны төлбөрт:

$$9'440 \text{ төг}/\text{м}^3 \times 20\% \times 0.1 = 188.8 \text{ төгрөг}$$





<p>9'440 төг/м<sup>3</sup>-Туул голын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ; 20% - Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 1-р хавсралтын 4-т заасан Авто замын зориулалтаар газрын доорх усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ; 0.1 – Авто зам, засварт газрын доорх усны нөөц ашигласан зориулалтыг тооцох итгэлцүүр. 480 м<sup>3</sup> x 188.8 төг = <b>90'624.0</b> /Ерэн мянга зургаан зуун хорин дөрвөн/ төгрөг Мод усалгаанд газрын доорх усны нөөц ашигласны төлбөрт: 9'440 төг/м<sup>3</sup> x 10% x 0.08 = 75.52 төгрөг 9'440 төг/м<sup>3</sup>-Туул голын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ; 1% - Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 2-р хавсралтын 2-т заасан Ургамал тарьж ургуулах зориулалтаар газрын доорх усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ; 0.08 – Ногоон байгууламжийн усалгаанд газрын доорх усны нөөц ашигласан зориулалтыг тооцох итгэлцүүр. 72 м<sup>3</sup> x 75.52 төг = <b>5'437.4</b> /Таван мянга дөрвөн зуун гучин долоон төгрөг дөчин мөнгө/  Нийт төлбөр: 600'346.0 төг + 90'624.0 төг + 5'437.4 төг = <b>696'407.4 төгрөг</b> /Зургаан зуун ерэн зургаан мянга дөрвөн зуун долоон төгрөг дөчөн мөнгө/</p> <p>Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасны дагуу ус ашиглах дүгнэлтээр тогтоосон хувь хэмжээгээр, (188.8 төг) усны тоолуурын заалтаар Налайх дүүргийн Татварын хэлтсийн дансанд төвлөрүүлнэ.</p> <p><b>15. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх, эргүүлж ашиглах даалгавар:</b> - Үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан хаягдал бохир усыг дахин ашигладаггүй.</p> <p><b>16. Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөгөө:</b> - Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу Нийслэлийн Байгаль орчны газраас ус ашиглах зөвшөөрөл авч, гэрээ байгуулан ажиллах шаардлагатай; - Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтын дагуу ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах; - Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 6.5-р заалтын дагуу үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23.2-т заасны дагуу тухайн дүүргийн Татварын хэлтэст төвлөрүүлэх шаардлагатай; - Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.18- дахь заалтын дагуу ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглах, дур мэдэн цооног гаргахыг хориглоно; - Гэрээнд зааснаас илүү ашигласан усанд Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор батлагдсан “Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журам”-ын дагуу шатлан өсгөх хэлбэрээр тооцохыг анхаарах; - Усны тоолуурын заалтын баталгаа алдагдсан, тоолуурыг шугам хоолойноос салгасан, тоолуургүй үйл ажиллагаа явуулсан тохиолдолд усны нөөц ашигласны төлбөрийг Байгаль орчин, ногоон хөгжил аялал жуулчлалын Сайдын 2015 оны А-301 дүгээр тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-оор тооцож ногдуулахыг анхаарах; - Ус ашиглуулах дүгнэлтээр ногдуулсан усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг хугацаанд нь төлөхгүй үйл ажиллагаа явуулбал Усны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.3 дахь заалтын дагуу ус ашиглах эрх цуцлагдах, Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар</p>
--



зүйлийн 7.15 дахь заалтын дагуу хариуцлага хүлээх нөхцөл үүсэхийг анхаарч ажиллах;

- Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 17 дугаар зүйлийн 17.1.5-д заасны дагуу сав газрын усны мэдээллийн дэд сан бүрдүүлэхэд шаардлагатай мэдээ тайлан, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тайланг 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн дотор Туул голын сав газрын захиргаанд ирүүлж ажиллах;

- Үйл ажиллагаа түр болон удаан хугацаагаар зогсолт хийсэн, эргэн ажиллах тухай бүрд холбогдох төрийн захиргааны байгууллагуудад даруй мэдэгдэж, тухайн оны ус ашиглалтын тайланд тусгаж оруулах;

- Ус ашиглуулах дүгнэлт болон хаягдал усны дүгнэлтийг тухайн жилийн эхний хагас жилд багтаан жил бүр гаргуулж байхыг анхаарах.

**ХЯНАСАН:**

УНУАЗА-НЫ ДАРГА

УНУАЗА-НЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН


**БОЛОВСРУУЛСАН:**

УНУАЗА-НЫ МЭРГЭЖИЛТЭН




П.ЭНХБАЯР

Д.УРАНЧИМЭГ



Н.ЦОГТ



зураг 3. Ус ашиглуулах дүгнэлт

БАТЛАВ  
ЧАНДМАНЬ НАЛАЙХ ОНӨААТҮГ-ЫН  
ЗАХИРАЛ *Сүх* БОЛДБААТАР  
2023 оны 09 сарын 14 өдөр

БАТЛАВ  
*Сүх* ХХК-ийн  
Засаг захирал *Сүх*  
2023 оны 09 сарын 14 өдөр

АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН  
БОХИР УС ТАТАН ЗАЙЛУУЛАХ ГЭРЭЭ

2023 оны 09 сарын 14-ны өдөр

№ 05

Налайх дүүрэг

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Монгол улсын “Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль”-ийн 13-р зүйлийн 13.2 дахь заалт, Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах аж ахуйн харилцааны дүрмийн 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн, Нэг талаас “Чандмань-Налайх” ОНӨААТҮГ /цаашид Хангагч гэх/-ыг төлөөлж Хуулийн зөвлөх ажилтай Л.Өнөрмаа, нөгөө талаас *Сүх* ХХК-ийн *Сүх* /цаашид Хэрэглэгч гэх/- төлөөлж *Сүх* ХХК-ийн *Сүх* ажилтай *Сүх* нар нь 2023 оны 09 сарын 14-ны өдрөөс 2024 оны 09 сарын 14-ны өдөр хүртэл 1 жилийн хугацаатай дор дурдсан нөхцөлийг биелүүлж ажиллахаар харилцан тохирч энэхүү гэрээг байгуулав. РД: *2723334*.

Хоёр. Хэрэглэгчийн эрх үүрэг

2.1 Хэрэглэгч нь дараах эрхтэй

- 2.1.1 Гэрээний дагуу бохир ус нийлүүлэх үйлчилгээ хийнэ.
- 2.1.2 Хангагч болон ажилтнуудын үйл ажиллагааны талаарх санал хүсэлт, гомдлыг “Чандмань-Налайх” ОНӨААТҮГ-ын диспетчерийн 70233310, 89953310 утсаар болон байгууллагын удирдлагад мэдээлэх, гомдол гаргах.
- 2.1.3 Өөрийн эзэмшлийн бохир ус нийлүүлэх үйлчилгээтэй холбоотой асуудлаар хангагчаас мэргэжлийн туслалцаа хүсэх, зөвлөгөө авах
- 2.1.4 Хэрэглэгч нь Налайх дүүрэг 5 дугаар хорооны цэвэрлэх байгууламжийн тогтоосон худагт бохирыг нийлүүлнэ.
- 2.1.5 Хэрэглэгч нь бохир ус хүлээн авах ажилтны заасан худагт бохирыг нийлүүлж, баримтжуулан баримт авна.

2.2 Хэрэглэгч нь дараах үүрэгтэй

- 2.2.1 Хэрэглэгч нь бохир ус нийлүүлэх төлбөрийг тухай бүр төлнө. /гэрээ хийхэд урьдчилан 30тн бохирын төлбөрийг төлнө.
- 2.2.2 Хангагч байгууллагатай заасан хугацаанд гэрээ байгуулах, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх
- 2.2.3 Хэрэглэгч өөрийн байршил, харилцагч банк, дансны дугаар, хаягийн бүртгэл солигдох бүрд гэрээнд тодотгол хийлгэх
- 2.2.4 Хэрэглэгч нь бохир усыг заасан худагт хийх ба бохир ус нийлүүлэх стандарт “MNS.6561:2015”-д стандартын шаардлагад нийцсэн бохир усыг нийлүүлнэ. Химийн бодис агуулсан буюу усанд уусахгүй бүхэл биет агуулсан бохир ус нийлүүлэхийг хориглоно.

Гурав. Хангагчийн эрх, үүрэг

3.1 Хангагч нь дараах эрхтэй.

- 3.1.2 Хэрэглэгчийн бохир ус нийлүүлэх стандарт шаардлага талаар мэргэжлийн заавар зөвлөгөө өгөх

3.2 Хангагч нь дараах үүрэгтэй

- 3.2.1 Хангагч нь хэрэглэгчийн хүсэлтээр төлбөртэй үйлчилгээг үзүүлэх
- 3.2.2 Хэрэглэгч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах, учирсан

Зураг 3. Хаягдал ус татан зайлуулах гэрээ



*Зураг 4. Зам талбай цэвэрлэж буй байдал*

## ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЭЛЭЛТ



2024 онд тоосгоны талбайн зүүн талд ойжуулалт хийсэн. Нийт 200 гаруй суулгац тарьсан. Нөхөн сэргээлтийн зургуудыг доор үзүүлэв.



*Зураг 5. Нөхөн сэргээлтийн ажил хийж буй байдал*



*Зураг 6. Шимт хөрсний овоолго үүсгэсэн байдал*

Бүртгэгдсэн		Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралт					
		<b>ТӨЛБӨРИЙН БАРИМТ</b>					
ДТД: 000002604663000240606000001390161 Борлуулагчийн: ТТД: 2745534 НЭР: Күнлүн Утас: ..... Банкны нэр: Банкны дансны дугаар:		Огноо: 2024-10-30 Хуудал авлагчийн: ТТД: 2745534 НЭР: КҮНЛҮН Хаяг: ..... Утас: 91161111, 99815238, 99815238, 99872563					
Д/д	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Код	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	
1	9431		ш	1	1,155,000.00	1,155,000.00	
						Бараа, ажил үйлчилгээний үнэ:	1,050,000.00
						Нэмэгдсэн өртгийн албан татвар:	105,000.00
						Нийслэл хотын албан татвар:	.00
						Нийт дүн:	1,155,000.00

## ДӨРӨВ. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 оны дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд Күнлүн ХХК нь Нийслэлийн байгаль орчин болоод Нүри ХХК-тай хамтран ойжуулах ажилд хамтран оролцсон. Доор ойжуулалтын тайланг үзүүлэв. ҮҮнд Күнлүн ХХК-аас 2,5 сая төгрөг зарцуулж 208 ширхэг мод тарисан болно.



Нийслэлийн байгаль орчны газар



Нүри ХХК



ТЭРБУМ МОД  
үндэсний хөдөлгөөн

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-НД ТУСГАГДСАНЫ ДАГУУ  
ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Танилцсан:

НБОГ-ын дарга

Р.Энхтайван

Танилцсан:

НБОГ-ын Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн хэлтсийн дарга

О.Тэмүүжин

Хянасан:

НБОГ-ын ХБОБНХ-ийн Газрын хэвгийн хяналт, нөхөн сэргээлт хариуцсан

мэргэжилтэн:

С.Сүхцөөж

Улаанбаатар хот

2024 он



## ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 83 зарлиг “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 2021 оны 56 дугаар зарлиг “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолын хавсралт “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний 27 дахь заалт “Ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн чиглэлээр орон нутагт ногоон ажлын байрыг нэмэгдүүлэх”, ажлын хүрээнд ойн мэргэжлийн байгууллага “Нүри ХХК” үндсэн болон гэрээт ажилчдыг зохион байгуулан 33 дахь заалт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд мод тарих, ургуулах, арчлах үйл ажиллагааг тусган хэрэгжүүлэх”, нийслэлд 120 сая мод тарих батламж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт “Ногоон ажлын байр хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хөнөөлт шавьж, өвчинд нэрвэгдсэн, хууль бус мод бэлтгэл болон сөрөг нөлөөлөлд өртсөн ойн нөхөн сэргээлт хийх, цөлжилтөөс болж шар шороон шуурганаас сэргийлэн ойн зурвас байгуулах ажлыг Инчон мөрөөдлийн төгөлд 4 га талбайд дүйцүүлэн хамгаалах ажлыг 2 дахь жилдээ тарьж байна.

## АЖЛЫН ЗОРИЛГО

“Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд дүйцүүлэн хамгаалах ажлыг гүйцэтгэх зорилготой бөгөөд дараах зорилтуудыг төлөвлөж ажилласан.

Үүнд:

1. Ойн зурвасын ажлын талбайн хэмжээг судалгаанд хамрагдсан газар нутгийн хүрээнд тогтоох
2. Судалгаанд хамрагдаж байгаа газарт ямар зүйлийн мод зонхилон ургаж болохыг тогтоох
3. Ойн зурвасын ажлыг гүйцэтгэсэн бүрэлдэхүүн.

Ойн зурвасын ажлыг Нийслэлийн байгаль орчны газар, “Нүри” ХХК-ны инженер, тенхикийн ажилтанууд Үүнд:

Гүйцэтгэгч:

- “Нүри” ХХК-ны захирал Х.Лхагважав
  - “Нүри” ХХК-ны ойн инженер А.Номин
  - “Нүри” ХХК-ны техникч Э.Гансүх
- Орон нутгийн улирлын түр ажилчин нийт 15 хүн хамтран ажилласан.

**4. Ойн зурвасын ажлыг гүйцэтгэж буй газар.**

Улаанбаатар хотын Сонгино хайрхан дүүргийн 21 хороонд байрлах “Инчон мөрөөдлийн төгөлд”:

- Талбайдаа мод тарих стандартын дагуу 5713 нүх ухав.
- 3 настай шинэс мод 1500ш
- 3 настай хайлаас мод 3113ш
- 4 настай нарс 1100ш
- 3 настай 3113 ш хайлаас, 1100ш нарс, 1500 ш шинэсийг намрын тарилтад бэлтгээд нэмэлтээр усны машин түрээслэж 10 хоногт 52 тонн усаар усалж байв.

Санхүүжилтын хүрээнд дараах үйл ажиллагааг гүйцэтгэв.


- Нүх ухаж тарилтанд бэлгэхэд
- Модны үнэ
- Холбогдох зардлыг тухай аж ахуйн нэгж байгууллагаад хариуцсан болно.

**7. Ойн зурвасын ажлыг гүйцэтгэсэн хугацаа**

Ойн зурвасын ажлыг 2024 оны 05-р сарын 05 -с 10-р сарын 26-ны хооронд хийж гүйцэтгэсэн.

Үйл ажиллагаа фото зураг

Мод тарих газрын тэмдэглэгээ хийж байгаа зураг



*Зураг 7. Дүйцүүлэн хамгаалах*

**ТӨРИЙН БАНК**  
ЭРСДӨЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

**МӨНГӨН ШИЛЖҮҮЛЭГ / MONEY TRANSFER**

Онг/Үү Сая/ММ Өдөр/ДД  
2024.10.28

**Хүлээн авагчийн / Beneficiary's:**

Банкны нэр / Bank name:	Дансны № / Account No:	Нэр (байгууллага эсвэл иргэн) / Name (organization or individual):
ГОЛЛОМТ БАНК	2705120425	НҮҮРИ ХХК
Мөнгөн дүн тоогоор / Amount:	Мөнгөн дүн үсгээр / Amount in words:	Валют / Currency:
2,500,000.00	Хоёр сая таяан зуун мянган тогтог	MNT
Гүйлгээний утга, бусад тэмдэглэл / Details of payment:		Нууц код / Code:
хүн лүү ххк-с рд2745534 дүйцүүлэх нөхөх сэргээх мод тарих у-88226064		

**Шилжүүлэгчийн / Sender's**

Банкны нэр / Bank name:	Дансны № / Account No:	Нэр (байгууллага эсвэл иргэн) / Name (organization or individual):
ТӨРИЙН БАНК	31253735	ЦЭВЭЛМЭЛЭ ИИ70121507 85226064
Мөнгөн дүн тоогоор / Amount:	Валют / Currency:	Гүйлгээний төрөл / Transaction type:
2,500,000.00	MNT	Банк хяналтын бичиг гүйлгээ-13600506
Харилцагчийн тэмдэглэл / Customer note:		

Тамга / Stamp: \_\_\_\_\_

Баталгаат гарын үсэг / Authorized signature:  
1. \_\_\_\_\_ 2. \_\_\_\_\_ 3. \_\_\_\_\_

**Банкны тэмдэглэл / For bank use only:**

Теллер №	Журнал №	Огноо	Гүйлгээний хураамж	Шилжүүлэгчийн бичгийн байцаалтын төрөл №	Теллер гарын үсэг
11502/3125	906790894301	2024.10.28 14:35	1,000.00		

Зураг 8. Дүйцүүлэн хамгаалах мод тарих төлбөрийн баримт

### **ТАВ.НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төслийн талбайн ойр орчмын нөлөөллийн бүсэд айл өрх болон ямар нэгэн нүүлгэн шилжүүлэх шаардлагатай зүйлс байхгүй тул нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөх шаардлагагүй болно.

### **ЗУРГАА.ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төслийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх, соёлын дурсгалт зүйлс, археологи, палеонтологийн олдвор тогтоогдоогүй. Цаашид уурхайн олборлолтын үйл ажиллагааны явцад ямар нэгэн түүх, соёлын дурсгалт зүйлс, булш, бунхан, хиргэсүүр зэрэг археологи, палеонтологийн зүйлс илрэх тохиолдолд Соёлын өвийг хамгаалах үүднээс төслийн үйл ажиллагааг түр зогсоож хууль ёсны дагуу мэргэжлийн байгууллагад хандаж мэдэгдэл хүргүүлэх шаардлагатай. арга хэмжээг авна.

## ДОЛОО. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын гэрээг байгуулж, хуваарийн дагуу тогтмол тээвэрлүүлсэн. /Хог хаягдлыг ачиж тээвэрлэх гэрээ болон санхүүгийн баримтыг хавсаргав./ Сар бүр 150 мян төгрөг зарцуулсан.



ХОГ ХАЯГДЛЫН ТӨЛБӨРТ  
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

24 05 09  
20... оны ... сарын ... -ны өдөр

№ 56

Налайх дүүрэг

Иргэн, ААНБ-ын нэр	Кvчvчvч ХХК
Регистрийн дугаар	2745534
Үйл ажиллагаа явуулж буй объектын оноосон нэр:	
Үйл ажиллагааны чиглэл	Тoосгoны нoмьбoр
Иргэн, ААНБ-ын хаяг	Эрхoрo бoгoбaдvчvчлoгдoй
ААНБ-ын холбогдох утас	88226064
Газар зүйн хязгаарлалт	Налайх дүүргийн .....3..... хороо
Данс:5749062084	Хаан банк
Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төрөл	Дvнoмoр
Төлбөрийн нөхцөл	Дoнoмoр
Гэрээний хугацаа	2024-5-9-с 2024-10-31-д

Энэхүү гэрээ нь Монгол Улсын хог хаягдлын тухай (шинэчилсэн найруулга) хууль, Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах, ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх харилцааг зохицуулах, аж ахуйн нэгж байгууллага, ХХЭрхлэгч нэг бүрийн үүрэг хариуцлагыг тодорхойлж дүгнэх, Эрүүл ахуйн тухай хууль, Нийслэлийн ИТХ-ийн Тэргүүлэгчдийн 2009 оны 63-р тогтоолоор батлагдсан “Хот тохижилт, цэвэрлэгээний талаар албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дагаж мөрдөх журам”, “Журамд өөрчлөлт оруулах тухай” Нийслэлийн ИТХ-ийн 2012 оны 61-р тогтоол, Налайх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 19/04 дугаар тогтоол болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн баримтална.

Нэг талаас Налайх дүүргийн Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ /цаашид “хог хаягдал тээвэрлэгч” гэх/ нөгөө талаас  
/иргэн, аж ахуй нэгж байгууллагын нэр/

Төлөөлж /цаашид “Хог хаягдал “тээвэрлүүлэгч” гэх ..... нар харилцан  
ажилтай ..... овогтой ..... нар харилцан  
тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү гэрээ нь Налайх дүүргийн .....-р хорооны нийтийн эзэмшлийн зам талбай, айл өрх, аж ахуй нэгж байгууллагын хог хаягдлыг цуглуулж, ачиж тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргэж хариуцсан бүсийг хог хаягдалгүй цэвэр байлгахад оршино.

1.3. Их цэвэрлэгээ болон бусад хог хаягдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр хороо болон бусад төрийн байгууллагатай хамтран ажиллана.

#### ХОЁР. ХОГ ТЭЭВЭРЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх чиглэл хуваарийг тогтоож ажиллана
- 2.2. Хог хаягдлыг зориулалтын битүүмжлэлтэй ажилгүй ажиллагааны шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.
- 2.3. Хог хаягдлыг тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолооч, ачигч нар нь зохих сургалтад хамрагдах аюулгүй ажиллагааны шаардлага хангаж ажиллана.
- 2.4. Хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх үед унах, асгарах, хийсэхээс сэргийлэх арга хэмжээ авна.
- 2.5. Овор хэмжээ ихтэй болон барилгын хог хаягдлыг ачиж тээвэрлэхдээ үйлчилгээний хөлс авч үйлчилнэ.
- 2.6. Хог хаягдлын тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт болон энэхүү гэрээний 3.3, 3.8 дахь заалтын хэрэгжилтэд хяналт тавьж хангалтгүй биелүүлсэн тохиолдолд шаардлага хүргүүлнэ.

#### ГУРАВ. ХОГ ТЭЭВЭРЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Хог тээврийн үйлчилгээний гэрээний төсөлтэй танилцаж, хог хаягдлын тухай хуулийн 10.2.3-д заасны дагуу гэрээ байгуулах
- 3.2. Хог хаягдлын тухай хууль түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт болон энэ гэрээний 2.2-2.6 дахь заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хангалтгүй биелүүлсэн тохиолдолд шаардлага тавих эрхтэй.
- 3.3. Хог хаягдлыг ангилах, ачих цуглуулах технологид нийцсэн, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн хогийн савтай байх ба хогийн саванд жилд ..... удаа холбогдох тусгай зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуй нэгж байгууллагаар ариутгал хийлгэж, ариутгал хийлгэсэн талаар тээвэрлэгч байгууллага болон мэргэжлийн холбогдох байгууллагад мэдэгдэх.
- 3.4. Хог хаягдлын талаарх сургалтад хамрагдах
- 3.5. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх аваагүй аж ахуй нэгж, байгууллагаас хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйлчилгээ авахыг хориглоно.
- 3.6. Хог хаягдлыг зориулалтын хогийн сав болон цэгээс хүлээлгэн өгөх ба авах хуваарийн дагуу ачих үед саадгүй тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Хөлдүү болон нурам үүссэн хогийг захиалагч өөрөө хариуцаж савлаж, унтрааж, хогийн сав болон орчноос бүрэн суллаж ачихад бэлтгэнэ.
- 3.7. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас үйл ажиллагаа явуулах боломжгүй болон тохиолдолд үйл ажиллагаа явуулах хугацааг урьдчилан мэдэгдэж хуваарьт өөрчлөлт оруулах хүсэлтийг бичгээр гарган нягтлан бодогчид өгнө.
- 3.8. Овор хэмжээ ихтэй болон барилгын хог хаягдлыг тээвэрлэгч байгууллагад шилжүүлнэ.

#### ДӨРӨВ. ТӨЛБӨР ТООЦОО

- 4.1. Монгол Улсын “Хог хаягдлын тухай (шинэчилсэн найруулга)” хуулийн 41 дүгээр зүйлийг үндэслэн хог хаягдал гарган төлбөрийг Налайх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 19/04 дугаар тогтоолоор батлагдсан төлбөрийн хэмжээгээр ..... төгрөгийг сар бүрийн ..... өдрийн дотор Хаан банк 5749062084 тоот дансанд аж ахуй нэгжийн нэр, утасны дугаар, хаягийг бичиж хугацаанд бүрэн төлнө.
- 4.2. Овор хэмжээ ихтэй болон барилгын хог хаягдлыг тээвэрлэх үйлчилгээний хөлс нь хог хаягдлын үйлчилгээний хураамжид хамаарахгүй. Үйлчилгээний хөлсийг гэрээгээр тохиролцсоны дагуу төлнө.



## НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт 2. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт*

Нөлөөллийг бууруулах арга хэмжээ
Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад байрлуулах, сайжруулах
Ажиллагсадыг тоосноос хамгаалах хошуувч, хувцас хэрэгслээр хангасан.
Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хяналт тавьж байх /ажил эхлэхийн өмнө/



*Зураг 10. Галын аюулгүй байдлыг хангасан байдал*



*Зураг 11. Аюулгүй байдлын тэмдэг тэмдэглэгээг байршуулсан байдал*






Зураг 12. Галын аюулгүй байдлын дүгнэлт

## ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт ус, агаар, дуу чимээ, хөрсны шинжилгээг мэргэжлийн байгуулгатай хамтран гүйцэтгэлээ.



### ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР БАЙГАЛЬ ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Улаанбаатар хот  
Утас: 11-341818 И-мэйл: [bohzt1@gmail.com](mailto:bohzt1@gmail.com)



### СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№	: 2024/388-389
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “Күн лүн” ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал	: Д.Сувд агаарын хэсэг
Сорьцын тоо, төрөл	: 2 хөрсний сорьц
Сорьц авсан огноо	: 2024.08.12
Сорьцын тодорхойлолт	: Улаанбаатар-Налайх дүүрэг 3-р хороо Баг Баян Уул 1-1 тоосгоны үйлдвэр
Шинжилгээний аргын стандарт	: САЗ А01:2022
Шинжилсэн огноо	: 2024.08.14
Хуудасны тоо	: 1/1

Үр дүн

№	Сорьц авсан цэгийн нэр	Кадми	Хар тугалга	Мөнгөн ус	Хром	Цайр	Зэс	Стронци
		(Cd)	(Pb)	(Hg)	(Cr)	(Zn)	(Cu)	(Sr)
		мг/кг						
1	Кемп орчим	1.3	14	<0.005	<0.5	74	29	438
2	Үйлдвэр орчим	1.7	27	<0.005	<0.5	134	25	381
	MNS 5850:2019/ ЗДХ	3	100	2	150	300	100	800

Шинжилгээ гүйцэтгэсэн:

Хянаж баталгаажуулсан:




Ахлах шинжээч Б.Даваасүрэн

Ахлах шинжээч Б.Алтантуяа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

Зураг 13. Хөрсний шинжилгээний хариу



ХӨРС СУДЛАЛЫН  
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Дугаар: 24/1879

ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК

Утас/Факс 77278899, 77288899

E-mail: soil\_lab@geo-mongol.mn mn

Дээж авсан огноо: 2024 он 10 сарын 21

Шинжилгээ хийсэн огноо: 2024 он 10 сарын 22-23

Дээж авсан газрын нэр: Улаанбаатар хот, Налайх дүүрэг, “Кунлун” ХХК

Координат: 47°44'52.0" 107°17'55.2"

Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: “Монслов” ХХК

Харилцах утас: 91999555

Хөрсний химийн задлан шинжилгээний дүн

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	pH	Давс, %	ЦДЧ, dsm	Ягмаг, %	NO <sub>3</sub> мг/ 100г	CaCO <sub>3</sub> , %	Шингээгдсэн сууриуд мг- экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/ 100 гр	
										Ca	Mg	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
0	1	2	3	4	5	6	7	8	10	11	12	13	14
1	24/5642	Хөрс-1	-	7.41	0.22	0.452	3.61	0.66	0.00	23.2	11.8	4.2	17

Хөрсний механик бүрэлдэхүүн

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм						
				1-0.25	0.25- 0.05	0.05- 0.01	0.01- 0.005	0.005- 0.001	<0.001	<0.01
1	24/5642	Хөрс-1	-	6.2	54.4	20.5	7.8	5.4	5.7	18.9

Хөрсний хүнд металл



№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Хүнд металл мг/кг					
				Ni /Никель/	Cd /Кадми	Pb /Хар тугалга/	Cu /Зэс/	Zn /Цайр/	Cr /Хром/
1	24/5642	Хөрс-1	-	15.06	ND	5.48	7.23	55.03	ND
Хүлцэх агууламж /MNS 5850:2019/				150,0	3,0	100,0	100,0	300,0	150,0
Хорттой агууламж /MNS 5850:2019/				1000,0	10,0	500,0	500,0	600,0	400,0
Аюултай агууламж /MNS 5850:2019/				1800,0	20,0	1200,0	1000,0	1000,0	1500,0
Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт				/MNS 5850:2019/					

\*ND-not detect

Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжэнд хамаарах ба хуульбарлан хэрэглэхийг хориглоно.

Шинжилгээ хийсэн арга стандарт:

(MNS 3310:1991, MNS ISO 10390:2001, MNS 6824:2020, MNS ISO 11466:2007)

Лабораторийн эрхлэгч:  Я.Болдбаатар /MS.c/  
Задлан шинжээч:  С.Ганцэцэг

Зураг 14. Хөрсний шинжилгээний хариу



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН  
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,  
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818  
E-mail: bohzt@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№	: 2024/ Ц-178
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “Күн-Лүн” ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал	: Д.Сувд, БОХЗТЛ
Сорьцын тоо, төрөл	: 1, ус
Сорьц авсан огноо	: 2024.08.08
Сорьцын тодорхойлолт	: Худгийн ус
Шинжилгээний аргын стандарт	MNS ISO 10523:2001, MNS ISO 7888:1999 MNS 1097:2023, MNS 4424:2005 MNS 6832:2020
Шинжилсэн огноо	: 2024.08.09-2024.08.28
Хуудасны тоо	: 2 /2
Үр дүн	: 1


Сорьц авсан цэг	pH	ЕС мкСи/см	SO <sub>4</sub> мг/л	Cl мг/л	Ca мг/л	Mg мг/л	Na+K мг/л	HCO <sub>3</sub> мг/л	Эрд мг/л	Хат мг-экв/л
НД, 3-р хороо Бага Баян-Уул 1-1 Тоосгоны үйлдвэр	7.31	287	36.1	5.3	29.1	9.7	30.2	156	266	2.25
<b>MNS 0900:2018</b>	<b>6.5-8.5</b>	<b>1000</b>	<b>500</b>	<b>350</b>	<b>100</b>	<b>30</b>	-	-	-	<b>7.0</b>

Тайлбар: ЕС - цахилгаан дамжуулах чанар, Хат-Хатуулаг, Эрд-Эрдэсжилт

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч:  А.Цолмонбаяр  
Шалгасан ахлах шинжээч: С.Отгонжаргал  
Хянаж баталгаажуулсан ахлах шинжээч: Б.Алтантуяа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.

Зураг 15. Усны шинжилгээний хариу



**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН  
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,  
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818  
E-mail: [bohzt@gmail.com](mailto:bohzt@gmail.com)



**СОРИЛТЫН ДҮН**

Дугаар он/№	: 2024/ Ц-178
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “Күн Лүн” ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал	: Сувд, БОХЗТЛ
Сорьцын тоо, төрөл	: 1, ус
Сорьц авсан огноо	: 2024.08.08
Сорьцын тодорхойлолт	: Худгийн ус
Шинжилгээний аргын стандарт	<b>MNS 6836:2020, MNS 6833:2020</b> <b>MNS 1097:2023, MNS 6779:2019</b> <b>MNS 6834:2020, MNS ISO 6878:2001</b> <b>MNS 4430:2006, MNS 6272: 2011</b>
Шинжилсэн огноо	: 2024.08.09-2024.08.28
Хуудасны тоо	: 1 /2
Үр дүн	: 1

Сорьц авсан цэг	Ж/б мг/л	ПИЧ мг/л	NH <sub>4</sub> мг/л	NO <sub>2</sub> мг/л	NO <sub>3</sub> мг/л	PO <sub>4</sub> мг/л	Fe мг/л	F мг/л
НД, 3-р хороо Бага Баян-Уул 1-1 Тоосгоны үйлдвэр	6.6	1.9	0.05	0.010	1.24	0.006	0.02	0.63
<b>MNS 0900:2018</b>	-	-	<b>1.5</b>	<b>1.0</b>	<b>50</b>	<b>3.5</b>	<b>0.3</b>	<b>0.7-1.5</b>

Тайлбар: Ж/б- Жинлэгдэгч бодис, ПИЧ Перманганатын Исэлдэх Чанар

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч:

Шалгасан ахлах шинжээч:

Хянаж баталгаажуулсан ахлах шинжээч:




А.Цолмонбаяр

С.Отгонжаргал

Б.Алтантуяа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцод хүчинтэй.

*Зураг 16. Усны шинжилгээний хариу*



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН  
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,  
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818  
E-mail: [bohzt1@gmail.com](mailto:bohzt1@gmail.com)

СОРИЛТЫН ДҮН



Дугаар он/№	: 2024/A-205
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: "КҮН ЛҮН"ХХК
Сорьцын авсан хүний нэр, албан тушаал	: Д.Сувд агаарын хэсэг
Сорьцын тоо, төрөл	: 1 агаар, 1 дуу чимээ
Сорьц авсан огноо	: 2024.08.08
Сорьцын тодорхойлолт	: Улаанбаатар Налайх дүүрэг 3-р хороо Баян-уул баг Тоосгоны үйлдвэр
Шинжилгээний аргын стандарт	: MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021 MNS 5002:2000, САЗ А07-2016
Шинжилсэн огноо	: 2024.08.12
Хуудасны тоо	: 1/1

Үр дүн :

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий	Азотын давхар исэл	Нийт тоос /TSP/	Дуу чимээ
					мг/м <sup>3</sup>		ДБА
1	Үйлдвэр орчим	VIII/09	15:40	0.010	0.022	0.291	54
Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016, Хүлцэх агууламж (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	60

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч :

Хянаж баталгаажуулсан:

Байгаль орчны шинжилгээний ахлах шинжээч :



Э.Оюунтуяа

Б.Алтантуяа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцод хүчинтэй

Зураг13. Агаар дуу чимээний шинжилгээний хариу

## **АРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулан холбогдох байгууллагуудад танилцуулахаар хүргүүлсэн болно. Мөн түүнчлэн уурхайн орчныг тохижуулж ногоон байгууламж байгуулсан.



*Зураг 17. Тосгоны орчим дахь ногоон байгууламж*

2024 онд ахуйн шавж, мэрэгч хортон аруйтгал хийлгэсэн . Мөн Күнлүн ХХК нь Налайх дүүргийн менежертэй нийгмийн хариуцлагын гэрээг байгуулан Налайх дүүргээс зохион байгуулсан арга хэмжээнд нийгмийн хагриуцлагын хүрээнд дэмжин хамтраж ажиллахаар болов. Үүнд аж ахуй нэгжийн хашаанд 100 ширхэг мод тарьж, дүүргийн ногоон байгууламж хариуцсан мэргэжилтэнд мэдэгдсэн.



2024 оны 6 сарын 8 өдөр

№

Налайх дүүрэг

Нэг: Ерөнхий зүйл

1.1 Нэг талаас /үйлчлэгч/ халдварт өвчний тархан дэлгэрэх нөхцлийг таслан ахуйн шавьж мэрэгч устгах, халдваргүйжүүлэлт хийх "Нандин-Өргөө" ХХК-ийг төлөөлж тус компаний захирал Д.Пүрэвжав нөгөө талаас /үйлчлүүлэгч/ байгууллагад .....ажилтай ..... нар тохиролцож 2024 оны 6-р сарын 8-ний өдрөөс эхлэн гэрээ байгуулав.

Хоёр: "Нандин-Өргөө" ХХК-иас хүлээх үүрэг

2.1 Үйлчлэгч тэл нь Эрүүл мэндийн тухай шинэчлэгдсэн хуулийн 41.1-р заалт болон МХЕГ-н даргын 2017-оны А/197-р тушаалаар батлагдсан /АХШМТэмцэх ариутгал халдваргүйтгэлийн байгууллагуудын ажиллах үлгэрчилсэн дүрэм/ нь дагуу ахуйн мэрэгч шавьж устгах, урьдчилан сэргийлэх ажлыг технологийн дагуу .....м2 эзэлхүүн талбайд ариутгал устгал халдваргүйжүүлэлтийн ажлыг хийнэ.

2.2 Ариутгал, устгал, халдваргүйжүүлэлтийг хийхийн тулд шавьж мэрэгчийн тархалтын түвшинг тогтоон, хорт бодисийн төрөл тун хэмжээг нарийвчлан тогтоож тэмдэглэнэ.

2.3 Илэрсэн шавьж мэрэгчийн хор хөнөөл болон урьдчилан сэргийлэх ариутгал халдваргүйтгэл хийх талаар зөвөлгөө өгч үйлчилгээ хийх өдөр цагийг тогтоон ажлын хөлсийг дараах тарифийн дагуу гаргуулж авна.

№	Үйлчилгээний нэр	Үнэ 1м2 талбайд		
		1000м2	1000-2000м2	2000м2-с дээш
1	Ахуйн хортон шавьж/ялаа, бясаа, жоом, цагаан эрвээхий/ устгах	600 төгрөг	500 төгрөг	400 төгрөг
2	Оготно, хулгана гэх мэт мэрэгч устгах	600 төгрөг	500 төгрөг	400 төгрөг
3	Халдварт өвчнөөс урьчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт	350 төгрөг	300 төгрөг	250 төгрөг

а. Үйлчилгээ хийх хор бодисыг MNS-1-2002 стандартын дагуу худалдан ав бэлтгэнэ.

б. Үйлчилгээний талаар тэмдэглэл бүртгэл хөтөлж үйлчилгээний үнэлгээ болон гарын үсгийг зуруулна.

в. Голомтот халдварт өвчин болон цар тахал гарсан үед халдваргүйтгэлийн ажлыг 14 хоногийн давтамжтай хийж гүйцэтгэнэ.

г. Үйлчилгээ хийгдэсний дараа 7, 14, 21 хоногт ажил үйлчилгээний үр дүнгийн талаар асуулт явуулах үзлэг шалтгалт хийх, баригч наалдуулагч тавьж шавьж мэрэгчийн тоог гаргах, үр дүнгийн талаар судалгааны хуудсанд тэмдэглэж цаашид авах арга хэмжээг төлөвлөнө.

Гурав: Үйлчлүүлэгч байгууллагаас хүлээх үүрэг

3.1 Үйлчлүүлэгч байгууллагаас Эрүүл мэндийн хуульд заасны дагуу ахуйн хортон шавьж мэрэгч устгах болон урьдчилан сэргийлэх ариутгал халдваргүйтгэлийн ажлыг жилд 2-оос доошгүй удаа мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгэнэ.



3.2 Халдварт өвчин дэлгэрсэн, ахуйн хортон шавьж мэрэгч тархсан, мэргэжлийн хяналтын байгууллагаас шаардлага тавьсан үед дуудлагаар үйлчлүүлнэ.

3.3 Ариутгал устгал халдваргүйжүүлэлт хийхийн өмнө тухайн орчинд цэвэрлэгээ хийж хогийг зайлуулан нүх цоорхойг бөглөж, цахилгаан хэрэгслийг түр салгаж, эд зүйлсийг хананаас зайдуу тавьж бэлтгэл хангана.

3.4 Дээрх шаардлагыг хангахгүйгээс үйлчилгээ хийлгэснээс хойш гарах асуудлыг бүрэн хариуцна.

3.5 Үйлчилгээний хөлсийг тарифийн дагуу төлнө.

Дөрөв: Төлбөр тооцоо

4.1 Төлбөрийг бэлнээр буюу нэхэмжлэхийн дагуу үйлчлэгч талд шилжүүлнэ.

4.2 Төлбөр тооцоог хугацаанд нь барагдуулаагүй тохиолдолд хоног тутамд 0,5% алданги төлнө.

Тав: Хариуцлага

5.1 Гэрээлэгч талууд хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй буюу гэрээний нөхцлийг зөрчсөн тохиолдолд нөгөө талын санаачлагаар энэхүү гэрээг цуцалж болно.

5.2 Бичиг баримтыг ашиглаж чанарын шаардлага хангаагүй бодисыг хувь хүнээс худалдан авсан тохиолдолд үүсэх хохиролыг үйлчлэгч тал хариуцахгүй.

5.3 Аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нөхцөлд учирсан хохиролыг Монгол улсын иргэнийн хуулийн дагуу шийднэ.

5.4 Гэрээг хоёр хувь үйлдэх ба эх хувиуд мөн адил хүчинтэй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Үйлчлэгч байгууллагыг төлөөлж:

"Нандин-Өргөө" ХХК-ний Менежер

ажилтай *Н. Огдхүү* /Н.Огдхүү/

Утас: 99451289, 99148255



Үйлчлүүлэгч байгууллагыг

төлөөлж *Ц.М. Уянга*

байгууллагын *Т.Х. Цырма*

ажилтай *Т.Х. Цырма*



ГЭРЭЭГ СУНГАСАН:

20...оны... сарын... өдрөөс

20...оны... сарын... өдрөөс

20...оны... сарын... өдрөөс

20...оны...сарын...өдөр хүртэл

20...оны...сарын...өдөр хүртэл

20...оны...сарын...өдөр хүртэл

Зураг 18. Ахуйн шавьж, мэрэгч устгах ариутгалын гэрээ

Улаанбаатар хотын налайх дүүргийн нутагт орших “Налайх гол-1” тоосгоны шаврын уурхайн  
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Хүснэгт 3. Биелэгдсэн байдал

№	Бүрэлдэхүүн хэсгүүд	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Тайлбар, үндэслэл
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	ш	3	-	Уурхайн гол замыг тогтмол услах, ТНСэргээлт хийх, ОХШХ-ийн дагуу хөрс, ус, агаарын чанарын шинжилгээ хийлгэх, шимт хөрсний овоолго үүсгэн хадгалах, хог хаягдлын гэрээг байгуулж, тогтмол тээвэрлүүлэх зэрэг төлөвлөсөн ажлуудыг хийж гүйцэтгэсэн.
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	га	1	-	2023 онд олборолтын үйл ажиллагаа явуулаагүй тул нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй.
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	ш	1	2 000.0	“Тэрбум мод ” үндэсний хөтөлбөрийн хүрээнд СХД-ийн нутаг “Инчон мөрөөдлийн төгөлд” мод тарих ажилд оролцсон.
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	-	-	-	2023 онд энэ чиглэлийн үйл ажиллагаа төлөвлөгдөөгүй болно.
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	ш	-	-	Ашиглалтын талбайн хэмжээнд түүх, соёлын дурсгалт зүйл илрээгүй
6	Осол эрдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	ш	3	3 500.0	.Галын аюулгүй байдлын дүгнэлт хийлгэсэн Ажилчдын хувцас хэрэгсэлээр хангасан.
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	ш	5	-	Налайг дүүргийн засаг дарга Здт
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийн тайлан	ш	4	-	
9	Олон нийгэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт	ш	3	-	2024 оны БОМТ-ний биелэлтийн тайланг боловсруулж, БОАЖЯ-ны цахим системд хугацаанд нь илгээсэн.
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	ш	3		ЦУОШГ-ын Байгаль орчны хэмжилзүйн лабораторид агаар, ус, хөрсний шинжилгээ хийлгэсэн.
	<b>Дүн</b>		<b>23</b>	<b>3500.0</b>	

## ДҮГНЭЛТ

Манай компани нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд НБОГ-тай хамтран ажилласан. Уг ажлын зардалд 25000.0сая төгрөг зарцуулсан болно.
- ✓ Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажилласан.
- ✓ Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд агаар, хөрс, усны шинжилгээ авч лабораторид шинжлүүлсэн.
- ✓ Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад байрлуулах, сайжруулсан
- ✓ Зам талбайг цэвэрлэж, чийгшүүлж ажилласан.
- ✓ Ус ашиглах гэрээ, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл, бохир соруулах үйлчилгээний гэрээг байгуулж тайланд хавсаргав.
- ✓ Ус ашиглах дүгнэлтийг Туул голын сав газрын захиргаанаас авсанг доор үзүүлэв.
- ✓ Налайх дүүргийн менежертэй нийгмийн хариуцлагын гэрээг байгуулан Налайх дүүргээс зохион байгуулсан арга хэмжээнд нийгмийн хагриуцлагын хүрээнд дэмжин хамтраж ажиллахаар болов. 100 ширхэг мод тарьсан.
- ✓ Овоолго болон бусад байгууламжуудыг байгуулхын өмнө өнгөн хөрсийг хуулж, өнгөн хөрсний овоолго байгуулж хадгалав.